



**ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН
МЭДҮҮЛЭГ НӨХӨН БИЧИХ
ГАРЫН АВЛАГА**

Улаанбаатар хот

2021.10.01

Гарчиг

Зургийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт.....	3
НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
Үйлчилгээ цэс.....	4
Бүрдүүлэлт цэс	5
Системд бүртгүүлэх.....	6
Системд нэвтрэх	6
ХОЁР. ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ НӨХӨН БИЧИХ ЗААВАР.....	8
Үндсэн мэдээлэл оруулах алхам.....	10
Ачаа эргэлтийн мэдээлэл оруулах алхам	15
Барааны мэдээлэл оруулах алхам	16
Бичиг баримтын мэдээлэл оруулах алхам.....	21
Хэрэглэгчийн цэстэй ажиллах.....	26

Зургийн жагсаалт

Зураг 1. Үйлчилгээ цэс харагдах байдал.....	5
Зураг 2. Бүрдүүлэлт цэс харагдах байдал	5
Зураг 3. Системд нэвтрэх товч	6
Зураг 4. Системд бүртгүүлэх	6
Зураг 5. Системд нэвтрэх.....	7
Зураг 6. Системд нэвтрэх нөхцөл зөвшөөрөх.....	7
Зураг 7. Үйлчилгээ цэс, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл харах хэсэг	8
Зураг 8. Экспорт, импортын барааны гаалийн мэдүүлэг танилцуулга	8
Зураг 9. Гаалийн мэдүүлэг нөхөн бичих	9
Зураг 10. Үндсэн мэдээлэл алхмын мэдээлэл оруулах хэсэг.....	10
Зураг 11. Үндсэн мэдээлэл алхамд мэдээлэл оруулсан байдал.....	14
Зураг 12. Ачаа эргэлт мэдээлэл алхмын мэдээлэл оруулах хэсэг	15
Зураг 13. Манифестын мэдээлэл татах хэсэг.....	16
Зураг 14. Бараана мэдээлэл алхмын бараа бүртгэх хэсэг	16
Зураг 15. Барааны мэдээлэл алхмын бичсэнээс хуулах цонх	17
Зураг 16. Барааны мэдээлэл алхмын бараа бүртгэх цонх	18
Зураг 17. Барааны мэдээлэл алхмын барааны жагсаалт хэсэг.....	21
Зураг 18. Бичиг баримтын мэдээлэл алхмын бүртгэх хэсэг	22
Зураг 19. Бичиг баримтын мэдээлэл бүртгэх цонх	22
Зураг 20. Бичиг баримтын жагсаалт харуулах хэсэг	23
Зураг 21. Хяналт цонх - хяналтын мэдээлэл зөрүүтэй үед харагдах хэсэг	24
Зураг 22. Хяналт цонх - хяналтын мэдээлэл зөрүүгүй.....	25
Зураг 23. Хүлээн авсан мэдүүлгийн төлөв харагдах хэсэг	25
Зураг 24. Бүртгэлтэй хэрэглэгчийн цэс харуулах хэсэг	26
Зураг 25. Бүртгэлтэй хэрэглэгчийн цэстэй ажиллах хэсэг	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Үндсэн мэдээлэл алхмын талбаруудын тайлбар	11
Хүснэгт 2. Ачаа эргэлтийн мэдээлэл алхмын талбаруудын тайлбар	15
Хүснэгт 3. Бараа бүртгэх хэсгийн талбаруудын тайлбар	19
Хүснэгт 4. Бичиг баримтын мэдээлэл хавсаргах хэсгийн талбаруудын талбар.....	23

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Гаалийн цахим үйлчилгээний систем нь иргэн, хуулийн этгээдэд гаалийн үйлчилгээг цахим хэлбэрээр нэг цэгээс хүргэх портал систем юм. Та www.gaali.mn хаягаар “Гаалийн цахим үйлчилгээний систем”-д хандах боломжтой бөгөөд сайтад хандсанаар

- ✓ Иргэн, ААН өөрсдөө гаалийн мэдүүлгээ нөхөн бичиж, дагалдах бичиг баримтыг цахимаар илгээх
- ✓ Гаалийн татвар хураамжийг цахимаар төлөх (Qpay, Social pay, Epayment), татварын буцаан олголтыг цахимаар авах
- ✓ Гаалийн байгууллагаас авах 3 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авах
- ✓ Экспорт, импортын мэдүүлэг явцыг харах, ачааны байршил шалгах, лавлагаа үйлчилгээний явц шалгах
- ✓ Гаалийн байгууллагаас олгож буй энгийн болон тусгай зөвшөөрлүүдийн талаарх мэдээ мэдээлэл авах
- ✓ Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН), хүсэлт илгээх
- ✓ Гаалийн төв лабораторид магадлан шинжилгээ хийлгэх хүсэлт илгээх
- ✓ Барааны ангилал (БТКУС)-ын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах, татвар хураамж болон бичиг баримтын тавигдах шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах
- ✓ Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл авах
- ✓ Гаалийн байгууллага, зуучлаг байгууллага, ачааны байршил, бүрдүүлэлтийн горим гэх мэт гаалийн байгууллагатай холбоотой олон нийтэд гаргаж буй лавлах сангийн мэдээлэл авах
- ✓ Гаалийн байгууллагатай холбоотой мэдээ мэдээлэл авах боломжтой.

Үйлчилгээ цэс

“Гаалийн цахим үйлчилгээний систем”-ийн “**Үйлчилгээ**” цэс дээр дарснаар гаалийн байгууллагаас цахимаар авч болох үйлчилгээнүүдийн жагсаалт гарч ирнэ. Үйлчилгээ цэс нь дэд төрлүүдтэй ба тухайн төрөлд хамаарагдах үйлчилгээнүүдээс хайлт хийх нь хэрэглэгчид илүү ойлгомжтой, цэгцтэй байх нөхцөлийг хангаж өгсөн. Мөн Иргэн, Аж ахуйн нэгж байгууллага авах үйлчилгээнүүдийг ангилж өгснөөрөө давуу талтай. Өөрт хэрэгтэй үйлчилгээгээ хайлтын хэсгээс үйлчилгээний нэрээр хайх боломжтой.

👤 Иргэн 🏢 Аж ахуйн нэгж байгууллага 🔍 Үйлчилгээний нэрээр хайх...

📄 Бүх үйлчилгээ	13	Лавлагаа, тодорхойлолт 3 үйлчилгээ
📄 Бүртгэл, хүсэлт	4	
📄 Лавлагаа, тодорхойлолт	3	
📄 Гаалийн бүрдүүлэлт	4	
📄 Төлбөр, тооцоо	2	

Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (Иргэн) дэлгэрэнгүй



Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа дэлгэрэнгүй

Гаалийн зөрчлийн лавлагаа (Иргэн) дэлгэрэнгүй

Зураг 1. Үйлчилгээ цэс харагдах байдал

Бүрдүүлэлт цэс

Бүрдүүлэлт цэсэд гаалийн бүрдүүлэлттэй холбоотой дараах 4 төрлийн мэдүүлэг байгаа бөгөөд дэлгэрэнгүй тайлбар уншсанаар аль мэдүүлгийг нөхөн бичихээ сонгон бичих боломжтой.



ГААЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМ
↻ Нэвтрэх

НҮҮР | БАРААНЫ АНГИЛАЛ, ТАТВАР | СТАТИСТИК | МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ | ЛАВЛАХ САН | ҮЙЛЧИЛГЭЭ | **БҮРДҮҮЛЭЛТ** |

Нүүр / Бүрдүүлэлт

👤 Иргэн 🏢 Аж ахуйн нэгж байгууллага 🔍 Үйлчилгээний нэрээр хайх...

Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг дэлгэрэнгүй	Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг дэлгэрэнгүй	Олон улсын шуудан илгээмжийн гаалийн мэдүүлэг дэлгэрэнгүй	Суудлын автомашины гаалийн мэдүүлэг дэлгэрэнгүй
---	--	---	---

*** “Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг”-ээр хувь хүний нэр дээр илгээсэн болон зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй барааны үнийн дүн 3.000.000 /гурван сая/ төгрөгөөс доош бол гаалийн бүрдүүлэлт хийнэ.

*** “Экспорт, импортын барааны гаалийн мэдүүлэг”-ээр хувь хүний нэр дээр илгээсэн болон зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй барааны үнийн дүн 3.000.001 төгрөг /гурван сая/-өөс дээш бол гаалийн бүрдүүлэлт хийнэ.


*** “Олон улсын шуудан илгээмжийн гаалийн мэдүүлэг”-ээр улс хоорондын шуудан илгээмжээр захидал, боодол, илгээлтийн хэлбэртэй биет зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх бол гаалийн бүрдүүлэлт хийнэ. Та илгээмжийн дугаараа заавал мэдэх ёстойг анхаарна уу.

*** “Суудлын автомашины гаалийн мэдүүлэг”-ээр гаалийн хилээр суудлын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх бол гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Зураг 2. Бүрдүүлэлт цэс харагдах байдал

Системд бүртгүүлэх

Системд нэвтрэх үйлдэл хийхийн тулд системд заавал бүртгүүлэх шаардлагатай. Системд бүртгүүлэхдээ сайтын баруун дээд буланд байрлах “Нэвтрэх” товч дээр дарахад шинэ хуудас үүсэх бөгөөд тухайн хуудасны “Бүртгүүлэх” товч дээр дарна.




Зураг 3. Системд нэвтрэх товч

Системд бүртгүүлэхдээ 2 төрлийн аргаар бүртгүүлнэ.

- ✓ Нэг удаагийн кодоор бүртгүүлэх – Өөрийн нэр дээр бүртгэлтэй утасны дугаараар бүртгүүлэх
- ✓ Интернет банкны эрхээр бүртгүүлэх - Өөрийн ашигладаг интернет банкны эрхээрээ бүртгүүлэх




ТАНИЛТ НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ХЭСЭГ



Зураг 4. Системд бүртгүүлэх

Системд нэвтрэх

“Гаалийн цахим үйлчилгээний систем”-ээс үйлчилгээ авах, мэдүүлэг бичихийн тулд системд заавал нэвтэрсэн байх шаардлагатай. Иргэн болон Аж ахуйн нэгж, байгууллага нь Үндэсний дата төвийн Танилт нэвтрэлт нэвтрэлтийн системийг ашиглан дараах аргуудаар системд нэвтрэх боломжтой.



Зураг 5. Системд нэвтрэх

- ✓ Нэг удаагийн кодоор нэвтрэх – Иргэний ашиглаж байгаа гар утасны дугаар тухайн иргэний өөрийн нэр дээр бүртгэлтэй тохиолдолд ДАН системд бүртгүүлэх боломжтой бөгөөд регистрийн дугаар болон ДАН системийн нууц үгийг оруулсны дараа хэрэглэгчийн утсанд ирүүлсэн нэг удаагийн кодоор баталгаажуулан нэвтрэх боломжтой.
- ✓ Тоон гарын үсгээр нэвтрэх – Иргэн өөрийн нэр дээр бүртгэлтэй иргэний тоон гарын үсгээр, аж ахуйн нэгж байгууллагын хувьд байгууллагын тоон гарын үсэг ашиглан нэвтрэх боломжтой.
- ✓ Банкны эрхээр нэвтрэх – Өөрийн нэр дээр бүртгэлтэй Хаан, Голомт, Худалдаа хөгжил, Капитрон, Төрийн банк гэх мэт интернэт банкны эрх болон төлбөр тооцооны Mostmoney, Socialpay аппликэйшний бүртгэлээрээ нэвтрэх боломжтой.


Дээрх аргуудаас аль нэгийг нь ашиглан нэвтрэх дарахад дараах цонх гарч ирэх бөгөөд **“Зөвшөөрөх”** товч дарснаар системд амжилттай нэвтрэнэ.



Зураг 6. Системд нэвтрэх нөхцөл зөвшөөрөх


ХОЁР. ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ НӨХӨН БИЧИХ ЗААВАР

“Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг үйлчилгээ”-г авахын тулд үйлчилгээний нэрийн ард байрлах “Дэлгэрэнгүй” товч дээр дарна.



Зураг 7. Үйлчилгээ цэс, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл харах хэсэг

“Экспорт, Импортын барааны мэдүүлэг” үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл доорх байдлаар харагдана.



Зураг 8. Экспорт, импортын барааны гаалийн мэдүүлэг танилцуулга

Дэлгэцэд тухайн үйлчилгээний талаарх дараах мэдээллүүд харагдана. Үүнд:

✓ **Танилцуулга**

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх зүйн орчны чиг үүрэгт заасан үйл ажиллагааны онцлогоос хамаарч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрийн үйлчилгээгээр хангах зорилгын талаар болон үйлчилгээний талаарх танилцуулга мэдээллийг оруулна.

✓ **Баримт бичиг**

Үйлчилгээний хүсэлт гаргагч төрийн үйлчилгээг олгох үндсэн шаардлага, тухайн байгууллагаас тодорхойлсны дагуу бүрдүүлэх бичиг баримтыг цахимаар хавсаргах жагсаалтыг харуулна.

✓ **Үйлчилгээний процесс**

Хүсэлт гаргагч системээс үйлчилгээ авах хүсэлт илгээх болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тухайн үйлчилгээний хүсэлтийг хүлээн авахаас эхлэн үр дүнг олгох хүртэлх шийдвэрлэх үйл ажиллагааны явцыг хүсэлт гаргагчид тодорхой харуулах мэдээллийг харуулна.

✓ **Төлбөрийн мэдээлэл**

Холбогдох үйлчилгээг үзүүлэхэд төлбөртэй эсэх талаарх мэдээлэл болон төлбөрийн зориулалт, ангилал, дансны мэдээллийг харуулна.


✓ **Хууль эрх зүй**

Тухайн үйлчилгээний хувьд эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичиг түүнийг дагалдан гаргасан журам заавар, стандарт маягт загварын мэдээллийг оруулж, холбогдох файлыг хавсаргана.

✓ **Асуулт хариулт**

Үйлчилгээ авах иргэн, аж ахуйн нэгжээс тухайн үйлчилгээтэй холбоотойгоор тогтмол ирдэг асуулт, мэдээллийг нэгтгэн боловсруулж үйлчилгээ авах явцыг хөнгөвчлөх зорилгоор Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зүгээс тодорхойлсон мэдээллийг харуулна.

Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг бөглөхийн тулд **“Гаалийн мэдүүлэг нөхөн бичих”** товч дээр дарснаар мэдүүлэг бөглөх талбар руу шилжинэ.



Зураг 9. Гаалийн мэдүүлэг нөхөн бичих

Гаалийн мэдүүлэг нөхөн бичих форм нь үндсэн 4 алхамтай.

- ✓ Үндсэн мэдээлэл
- ✓ Ачаа тээврийн мэдээлэл
- ✓ Барааны мэдээлэл
- ✓ Бичиг баримтын мэдээлэл

Үндсэн мэдээлэл оруулах алхам

“Үндсэн мэдээлэл” алхам нь худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл нөхөн бичих хэсэг бөгөөд дараах талбаруудыг бөглөнө.

Мөн * тэмдэглэгээтэй талбарын мэдээллийг заавал оруулахыг анхаарна уу.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

← Жарсаалт

1 Үндсэн мэдээлэл
Худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл нөхөн бичих

2 АЧАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ
Бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих

3 БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ
Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нөхөн бичих

4 БИЧИГ БАРИМТЫН МЭДЭЭЛЭЛ
Худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах.

* Гаалийн хил нэвтрүүлэх ялгаа: Импорт Экспорт

* Мэдүүлгийн төрөл: Мэдүүлгийн төрөл

* Бүрдүүлэлтийн горим: Бүрдүүлэлтийн горим

* Гаалийн байгууллага: Гаалийн байгууллага

* Мэдүүлсэн огноо: 2021-10-03

* Илгээгч: Улс Илгээгч нэр Илгээгч утас

Хаяг

* Илгээгч улс: Илгээгч улс

* Хүлээн авагч улс: Хүлээн авагч улс

* Санхүүгийн хувьд хариуцагч: Регистр Нэр Банк Дансны дугаар

Хаяг

Мэдүүлэгч өөрөө бол тэмдэглэх

* Илгээх үеийн тээврийн хэрэгсэл: Тээврийн төрөл Улс

* Хилийн боомт: Хилийн боомт Хяналтын бүс

Гэрээлэгч улс: Гэрээлэгч улс

* Бараа нийлүүлэх нөхцөл: Бараа нийлүүлэх нөхцөл Боомт

* Хэлцлийн код: Хэлцлийн код

* Төлөлтийн код: 201 Бэлэн бусаар тушаасан

* Валютын төрөл: Валют тухайн ... 2021-10-03 ам.долл. USD ам

* Хэлцлийн ерөнхий дүн: 0.00

Бүрдүүлэлтийн хураамж: 0.00 [MNT] Монгол төгрөг

Тээврийн зардал: 0.00 Валют

Даатгалын хураамж: 0.00 Валют

Нэмэгдэх зардал: 0.00 Валют

Хасагдах зардал: 0.00 Валют

Хянах Хадгалах Үргэлжлүүлэх >

Зураг 10. Үндсэн мэдээлэл алхмын мэдээлэл оруулах хэсэг

Хүснэгт 1. Үндсэн мэдээлэл алхмын талбаруудын тайлбар

Талбарын нэр	Дэлгэрэнгүй тайлбар
Гаалийн хил нэвтрүүлэх ялгаа	Гаалийн хил нэвтрүүлэх ялгаа буюу Импорт/Экспорт төрлийн аль нэгийг сонгоно.
Мэдүүлгийн төрөл	Системд тодорхойлсон төрлүүдээс сонгоно.
Бүрдүүлэлтийн горим	Системээс тодорхойлсон төрлүүдээс сонгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг https://gaali.mn/categories/procedure холбоосоор авах боломжтой.
Гаалийн байгууллага	Барааг мэдүүлэх гаалийн байгууллагыг сонгоно.
Мэдүүлсэн огноо	Барааг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа он, сар, өдрийг сонгож оруулна.
Илгээгч	Эхний талбарт барааг илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний харьяалагдах улсын нэрийг сонгож оруулна. Нэр хэсэг дээр барааг илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэрийг нөхөн бичнэ. Илгээгчийн иргэний нэр, хаягийг кирилл үсэгт хөрвүүлэх шаардлагагүй бөгөөд, эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ. Жишээ нь: Erlan Jiayu Trading Co.,Ltd г.м Мөн хаяг, утас зэрэг мэдээллийг бичиг баримтыг үндэслэн бичнэ.
Илгээгч улс	Тээврийн бичиг баримтад бичигдсэн барааг илгээгч улсыг сонгоно.
Хүлээн авагч улс	Тээврийн бичиг баримтад бичигдсэн барааг хүлээн авагч улсыг сонгоно.
Санхүүгийн хувьд хариуцагч	Гадаад худалдааны төлбөр тооцоо хийсэн санхүүгийн хувьд хариуцагчийн регистр №, нэр, банкны нэр, дансны дугаар, хаягийн мэдээллийг оруулна. Санхүүгийн хувьд хариуцагч нь мэдүүлэгч өөрөө бол тэмдэглэснээр тухайн хэрэглэгчийн мэдээлэл системээс автоматаар бөглөгдөнө.
Илгээх үеийн тээврийн хэрэгсэл	Системээс тодорхойлсон тээврийн төрлүүд болон илгээх улсаа сонгоно.
Хилийн боомт	Хил нэвтэрсэн боомтын нэрийг оруулах ба ачааны манифестын мэдээллээс автоматаар татагдана.
Гэрээлэгч улс	Бараа нийлүүлэхээр гэрээ байгуулсан гадаад гэрээлэгчийн харьяалагдах улсын нэрийг сангаас сонгоно.
Бараа нийлүүлэх нөхцөл	Гадаад худалдааны гэрээ хэлцлийн дагуу талуудын харилцан тохирсон бараа нийлүүлэх нөхцөлийг инкотермсийн нэр томъёог ашиглан

	сангаас сонгож оруулна. EXW, FOB, CIF, DDU гэх мэт.
Хэлцлийн код	Системээс тодорхойлсон төрлүүдээс сонгоно.
Төлөлтийн код	Тухайн барааны татварын төлөлтийг ямар аргаар хийж байгааг сангаас сонгоно. Жишээ нь: Бэлэн мөнгө тушаасан-101, Бэлэн бусаар тушаасан -201, Урьдчилсан төлбөрөөс суутгал хийсэн-301 гэх мэт.
Валютын төрөл	Гэрээ хэлцэлд заасан үнийн валютын төрлийг сонгох ба тухайн валютын төгрөгтэй харьцах ханш автоматаар тооцогдоно.
Хэлцлийн ерөнхий дүн	Үнийн нэхэмжлэхийн үнийн дүн буюу тухайн ачилтад хамрагдах бүх барааны нийт үнийн дүнг өмнө сонгосон валютаар илэрхийлж бичнэ. Жишээ нь: Гэрээнд 119 тонн цагаан будааг 1 тонныг нь 600 ам.долларын үнээр худалдан авахаар гэрээ байгуулсан ба барааны нийт үнийн дүн 71400 ам.доллар байна. Энэ тохиолдолд хэлцлийн ерөнхий дүн дээр 71400 гэсэн тоо утгыг оруулна.
Бүрдүүлэлтийн хураамж	Систем цаанаасаа бодож мөнгөн дүн тавина.
Тээврийн зардал	Монгол улсын хилийн боомт хүртэлх барааг тээвэрлэх, ачих буулгах, шилжүүлэн ачихад гарсан хэлцлийн буюу гэрээний үнэнд ороогүй дараах зардлын дүнг бичнэ. Үүнд: ✓ Тээврийн зардал, тээврийн болон экспортын бичиг баримт бүрдүүлэхэд гарсан зардал, тээврийн хэрэгсэл болон чингэлэг ашиглалтын хөлс, түрээсийн төлбөр; ✓ Тээвэрлэлтийн үед барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачих болон арчлан хамгаалахад гарсан зардал.
Даатгалын хураамж	Даатгалын хураамж гэдэгт импортын оронд тухайн барааг хүргэхтэй холбогдон гарах тээвэрлэлт, ачих буулгах, хадгалах, зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор хийсэн хэлцлийн буюу гэрээний үнэнд ороогүй даатгалын зардал хамаардаг. Монгол улсын хилийн боомт хүртэл гарах даатгалын хураамжийн дүнг бичнэ.

Нэмэгдэх зардал	Хэлцлийн үнэнд нэмэгдвэл зохих тээвэрлэлт, даатгалын зардлаас бусад, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн IV, V бүлэгт заасан бусад нэмэгдэх зардлын дүнг бичнэ.
Хасагдах зардал	<p>Хэлцлийн буюу гэрээний үнэд орсон бөгөөд тусдаа ялгарч харагдах тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн, гадаад худалдаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэслэлтэй мэдээ баримтад тулгуурлан дараах зардлыг хасаж тооцно.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Тоног төхөөрөмжийг импортолсны дараа суурилуулах, угсрах, засварлах болон техникийн туслалцаа үзүүлэх, сургалт явуулах зардал; ✓ Гаалийн хилээр оруулсны дараах тээврийн зардал; <p>Импортлогч орны гаалийн болон бусад татвар.</p>

Үндсэн мэдээлэл оруулах алхмын бүх талбаруудыг бөглөж дууссаны дараа **“Хадгалах”** товч заавал дарна.

Жич: Заавал бөглөх талбарууд бүрэн бөглөгдөөгүй үед алдаа заахыг анхаарна уу. Мөн **“Хадгалах”** товч дарсны дараагаар **“Үргэлжлүүлэх”** товч дарж дараагийн алхам руу шилжих боломжтой.

Импортын мэдүүлгийн үндсэн мэдээллийг хадгалсны дараа дараах байдалтай харагдана.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

[← Жагсаалт](#)

Мэдүүлгийн дугаар	I-12121675-00012	Горим	400:	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	БЯМБАСҮРЭН	Мэдүүлсэн огноо	2021-09-28 12:00	Барааны нэр төрөл	-
Барааны байршил	[302001] АБТЭМА	Мэдүүлгийн төлөв	• Хадгалсан :		

1 Үндсэн мэдээлэл
Худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл нөхөн бичих

2 АЧАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ
Бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих

3 БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ
Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нөхөн бичих

4 БИЧИГ БАРИМТЫН МЭДЭЭЛЭЛ
Худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах.

* Гаалийн хил нэвтрүүлэх ялгаа: Импорт Экспорт

* Мэдүүлгийн төрөл: 10 Энгийн

* Бүрдүүлэлтийн горим: 400 Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах

* Гаалийн байгууллага: 02201 Улаанбаатар дахь гаалийн газар Бүрдүүлэлтийн 1-р алба

* Мэдүүлсэн огноо: 2021-09-28

* Илгээгч: БНХАУ | CN Zhejiang jindalai Decorat Илгээгч утас
Wushan village Xiaoyue street, Shangyu area Shaoxing city

* Илгээгч улс: БНХАУ | CN

* Хүлээн авагч улс: Монгол | MN

* Санхүүгийн хувьд хариуцагч: 1151071: Экстрэм-Эссэнс ХХК Хаан банк 5034556278
УБ хот, БГД, 4-р хороо, нарны зам, 8а 1-р давхар тоот

Мэдүүлэгч өөрөө бол тэмдэглэх

Гэрээлэгч улс: БНХАУ | CN

* Бараа нийлүүлэх нөхцөл: EXW Үйлдвэрээс, агуулахаас ачих (v) Боомт

* Хэлцлийн код: 110 Валютын төлбөртэй бараа

* Илгээх үеийн тээврийн хэрэгсэл: 20 Төмөр зам БНХАУ | CN

* Хилийн боомт: B04201 Алтанбулаг - авто замын 304002 АЛТАНБУЛАГ

* Төлөлтийн код: 201 Бэлэн бусаар тушаасан

* Валютын төрөл: CNY БНХАУ-ын юань 441.0t 2021-09-28 2849.: USD

* Хэлцлийн ерөнхий дүн: 185797.000000 [CNY] БНХАУ-ын юань

Бүрдүүлэлтийн хураамж: 0.000000 [MNT] Монгол төгрөг

Тээврийн зардал: 1067210.950000 CNY БНХАУ-ын юань

Даатгалын хураамж: 0.00 CNY БНХАУ-ын юань

Нэмэгдэх зардал: 0.00 CNY БНХАУ-ын юань

Хасагдах зардал: 0.00 CNY БНХАУ-ын юань

[🔍 Хянах](#) [📄 Хадгалах](#) [🔗 Үргэлжлүүлэх >](#)

Зураг 11. Үндсэн мэдээлэл алхамд мэдээлэл оруулсан байдал

Ачаа эргэлтийн мэдээлэл оруулах алхам

“Ачаа эргэлтийн мэдээлэл” алхам нь бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих хэсэг бөгөөд дараах талбаруудыг бөглөнө. Мөн * тэмдэглэгээтэй талбарын мэдээллийг заавал оруулахыг анхаарна уу.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ ← Жггсаалт


Мэдүүлгийн дугаар	I-12126502-00001	Горим	400	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	ДОЛГОРЖАВ	Мэдүүлсэн огноо	2021-10-04 12:00	Барааны нэр төрөл	-
Барааны байршил	-	Мэдүүлгийн төлөв	• Хадгалсан :		

- ✓ **Үндсэн мэдээлэл**
Худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл нөхөн бичих
- 2 **АЧАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ**
Бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих
- 3 **БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ**
Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нөхөн бичих
- 4 **БИЧИГ БАРИМТЫН МЭДЭЭЛЭЛ**
Худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах.

- Хил дээрх тээврийн хэрэгсэл: Тээврийн төрөл Улс
- Тээврийн хэрэгслийн дугаар: Тээврийн хэрэгслийн дугаар
- Ачиж буулгах газар: Ачиж буулгах газар
- Барааны байршил: Барааны байршил
- Гаалийн бүсэд орсон огноо: Гаалийн бүсэд орсон огноо Чингэлзгийн дугаар

Ачааг гаалийн хяналтад авсан бүртгэл (ачааны манифест, эсхүл тээврийн хэрэгслийн бүртгэл)-ийн мэдээлэл

• Нийт манифест: 0

Манифестын №	ТБ №	Баглаа боодол	Цэвэр жин	Бохир жин	Үйлдэл
 Мэдээлэл бүртгээгүй байна.					

+ Манифест нэмэх
+ Тээврийн хэрэгсэл нэмэх

< Буцах
🔍 Хянах
📄 Хадгалах
🔄 Үргэлжлүүлэх >

Зураг 12. Ачаа эргэлт мэдээлэл алхамын мэдээлэл оруулах хэсэг

Хүснэгт 2. Ачаа эргэлтийн мэдээлэл алхамын талбаруудын тайлбар

Талбарын нэр	Дэлгэрэнгүй тайлбар
Хил дээрх тээврийн хэрэгсэл	Эхний хэсэгт Монгол улсын хилээр бараа нэвтрүүлэх үеийн тээврийн төрлийг сонгоно, дараагийн хэсэгт тээврийн хэрэгслийн харьяалагдах улсын сонгоно.
Тээврийн хэрэгслийн дугаар	Тээврийн хэрэгслийн дугаарыг бичнэ. Энэ нь ачааны манифестын мэдээллээс автоматаар татагдах ба зөв татагдсан эсэхийг тулган шалгана.
Ачиж буулгах газар	Барааг буулгах газар, өртөөний кодыг эхний хэсэгт, нэрийг дараагийн хэсэгт бичнэ. Гаалийн хилээр оруулах барааны хувьд хилээр тээвэрлэж оруулсан тээврийн хэрэгслээс барааг буулгасан газрын кодыг бичнэ.
Барааны байршил	Барааг гаальд мэдүүлэх үед тухайн бараа байрлаж буй гаалийн хяналтын бүсийг сонгож оруулна.
Гаалийн бүсэд орсон огноо	Гаалийн хяналтын бүсэд оруулсан он, сар, өдрийг оруулна.

“**Манифест нэмэх**” товч дээ дарснаар доорх цонх гарч ирэх ба өөрт байгаа нийт манифестын мэдээллийг жагсаалтаар харуулна. Мөн манифест дугаар, чингэлэг дугаар, огноо, тээврийн баримтын дугаар зэргээр манифестын жагсаалтаас хайлт хийх боломжтой.

МАНИФЕСТЫН ЖАГСААЛТ

Манифест №: Чингэлэг №: Огноо:

Тээврийн баримтын №: **Хайх**

Нийт: 0

Манифест №	ТБ №	ТХ №	Баглаа боодол	Цэвэр жин	Бохир жин
Мэдээлэл байхгүй байна					

Зураг 13. Манифестын мэдээлэл татах хэсэг

Барааны мэдээлэл оруулах алхам

“Барааны мэдээлэл” алхам нь барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт бараатай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл нөхөн бичих хэсэг бөгөөд “**Бичсэнээс хуулах**”, “**Бараа нэмэх**” гэсэн 2 төрлөөр барааны мэдээлэл оруулах боломжтой.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

Мэдүүлгийн дугаар	I-12126502-00001	Горим	400	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	ДОЛГОРЖАВ	Мэдүүлсэн огноо	2021-10-04 12:00	Барааны нэр төрөл	-
Барааны байршил	[301005] ГЕГ БДШГ	Мэдүүлгийн төлөв	Хадгалсан		

Үндсэн мэдээлэл
 Худалдагч, худалдан авагчийг холбоотой хэлцлийн мэдээлэл нэмэн бичих.

Ачаа зэргэлтийн мэдээлэл
 Бараа, тээврийн хэрэгслийн нөхцөлөөнтэй холбоотой мэдээлэл нэмэн бичих.

БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ
 Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нэмэн бичих.

Бичиг баримтын мэдээлэл
 Худалдааны болон бусад далайсан бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах.

Нийт бараа: 0

Барааны нэр	Хэлцлийн тоо хэмжээ	Хэлцлийн нэгж үнэ	Баглаа боодол	Нийт татварын дүн	Үйлдэл
Мэдээлэл бүртгэгүй байна					

Зураг 14. Барааны мэдээлэл алхмын бараа бүртгэх хэсэг

“Бичсэнээс хуулах” товчийг дарахад өмнө нь бичиж байсан нийт мэдүүлгийн барааны жагсаалтыг харуулна. Жагсаалтаас бараагаа сонгон “Хуулах” товч дарснаар барааны мэдээллийг тэр чигт нь хуулах бөгөөд хуулсны дараагаар тухайн барааны мэдээллийг засаж хадгалах боломжтой. Ижил төрлийн барааг олон удаа мэдүүлж байгаа үед энэ үйлдлийг ашигласнаар мэдүүлгийн мэдээллийг хурдан зөв бөглөх боломжоор хангаж өгснөөрөө давуу талтай.

БАРААНЫ ЖАГСААЛТ
✕

Огноо: Барааны нэр:

БТКУС:

Нийт: 10

	БТКУС	Нэр	Хэлцлийн тоо хэмжээ	Хэлцлийн нэгж үнэ	Баглаа боодол	Ангиллын тоо хэмжээ	Цэвэр жин	Бохир жин
<input checked="" type="radio"/>	33011300	test	2	1	1 BG	2 KG	2	12
<input type="radio"/>	33011900	test	2	2	1 BG	4 KG	4	5
<input type="radio"/>	33011300	test	2	1	1 BG	2 KG	2	12
<input type="radio"/>	33011900	test	2	2	1 BG	4 KG	4	5
<input type="radio"/>	02032100	Гахайн мах	23	5000	0 null	1200 KG	1200	1300
<input type="radio"/>	02023010	Үхрийн мах	24	7000	0 null	2100 KGM	23000	23000
<input type="radio"/>	42031020	Тест бараа 1	0	0	0 null	0 U	240	300
<input type="radio"/>	94042900	Матрац	1	1.7	1 CY	1 U	24	24
<input type="radio"/>	63090000	Хувцас, хуучин	135	4.47	135 BE	4490 KG	4490	4500
<input type="radio"/>	95069900	Туухай, дасгалын	10	0.5	3 BE	10 U	300	300

< 2 3 4 5 >
10/хуудас
Шилжих

Зураг 15. Барааны мэдээлэл алхмын бичсэнээс хуулах цонх

“**Бараа нэмэх**” товчийг дарахад барааны мэдээлэл оруулах цонх гарч ирэх бөгөөд тухайн цонхонд барааны дэлгэрэнгүй мэдээлэл оруулан “Хадгалах” товчийг дарснаар барааны мэдээллийг бүртгэнэ. Мөн * тэмдэглэгээтэй талбарын мэдээллийг заавал оруулахыг анхаарна уу.

БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ БҮРТГЭХ X

* БТКУС-ийн код:

* Гарал үүслийн улс:

* Тарифын төрөл:

* Оноосон нэр:

Үйлдвэрлэгч:

Марк (Модель):

Онцлог шинж:

Бусад мэдээлэл:

Үйлдвэрлэсэн он сар:

Бар код:

Квот:

* Хэлцлийн нэгж үнэ:

* Хэлцлийн тоо хэмжээ:

Ангиллын нэгж үнэ:

* Ангиллын тоо хэмжээ:

* Шилжих коэффициент:

Баглаа боодол:

* Цэвэр жин:

* Бохир жин:

Зураг 16. Барааны мэдээлэл алхмын бараа бүртгэх цонх

Хүснэгт 3. Бараа бүртгэх хэсгийн талбаруудын тайлбар

Талбарын нэр	Дэлгэрэнгүй тайлбар
БТКУС-ийн код	Барааны ангиллын кодыг Уялдуулсан системийн дагуу заавал 8 оронтой ангиллын кодыг сангаас сонгож оруулна. Барааны нэр болон кодоор хайлт хийж ангиллын кодыг сонгох боломжтой.
Гарал үүслийн улс	Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг үндэслэн гарал үүслийн улсын нэрийг сонгож оруулна.
Тарифын төрөл	<p>Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг үндэслэн тарифын төрлийг сонгож оруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нэн тааламжтай тариф: - ДХБ-ын гишүүн орнууд болон Беларусь Улсын гарал үүсэлтэй бараанд хэрэглэнэ. Гарал үүслийг нотлох баримт хавсаргасан байна. ✓ Ердийн тариф: - Гарал үүслийг нотлоогүй тохиолдолд ердийн тарифыг хэрэглэнэ. Нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. ✓ Хөнгөлөлттэй тариф: - Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу Япон Улсын гарал үүсэлтэй бараанд хэрэглэнэ. ЭЗТХ-ийн гарал үүслийн гэрчилгээ хавсаргана.
Оноосон нэр	Барааны ерөнхий нэрийг бичиж таслал тавин, тухайн барааг тодотгосон онцлог шинжийг бичнэ. Жишээ нь: Тамхи, янжуур, шүүлтүүртэй; Будаа, цагаан, өнгөлсөн гэх мэт
Үйлдвэрлэгч	Барааг үйлдвэрлэсэн компанийн нэрийг бичнэ. Жишээ нь: телевизор-Sony, LG, эмнэлгийн тоног төхөөрөмж Philips, Taewoong Medical co.,LTD, гоо сайхны барааUnilever, B36 & Gamble. будаа - Organic Rice Company гэх мэт бичнэ.
Марк (Модель)	Барааны брэнд нэр, стандарт, артикул, загвар, сорт зэргийг тухайн барааны онцлогтой уялдуулан бичнэ. Барааны брэнд нэрийг хэлцэлд туссан байдлаар нь бичих бөгөөд гадаад нэрийг кирилл үсэгт хөрвүүлэхгүй. Эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ. Тухайлбал: Esse, Tide, Ariel гэх мэт. Стандартын үсгэн тэмдэглэгээг том үсгээр бичнэ
Онцлог шинж	Барааны зориулалт, агууламж, онцлог шинж, чанар, зэрэг, техникийн үзүүлэлт, хүчин чадал, хэмжээ, барааны шинж байдал, тодорхойлолт, савлагаа бичнэ. Тухайлбал: тамхи-

	Тхайрцаг*50блок*10ж/х*20ш, бохь 20мг, ник 1.6мг, Шампунь тэжээлийн, чийгшүүлэгчтэй, Тхайрцаг*6 ш*250мл, с/жин-53гр, үс арчилгаа.
Бусад мэдээлэл	Дээрх талбаруудад ороогүй боловч тухайн барааны үнэ, ангилалд нөлөөлөх бусад мэдээллийг оруулна.
Үйлдвэрлэсэн он	Барааны үйлдвэрлэсэн он бичнэ.
Бар код	
Квот	
Хэлцлийн нэгж үнэ	Гэрээ хэлцэлд туссан хэмжих нэгжээр илэрхийлсэн нэгж үнийг оруулна. Дээрх жишээний дагуу хэлцлийн нэгж үнэ нь 600 ам.доллар
Хэлцлийн тоо хэмжээ	Барааны гэрээ хэлцэлд нэгж үнийг тохирсон хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн тоо хэмжээг оруулна. Жишээ нь: Нотлох бичиг баримтад 119 тонн гэж заасан бол хэлцлийн тоо хэмжээ нь 119 бөгөөд хэмжих нэгж нь тонн байна. Хэлцлийн тоо хэмжээ хүснэгтэд 119, харин тонн гэсэн хэмжих нэгжийг сангаас сонгож оруулна.
Ангиллын нэгж үнэ	БТКУС-ийн ангилал хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн суурь нэгж үнийг программаас автоматаар тооцож гаргадаг.
Ангиллын тоо хэмжээ	БТКУС-ийн ангилал хүснэгтэд Уялдуулсан системийн дагуу 8 оронгийн түвшинд ангиллын кодыг бичихэд ангиллын хэмжих нэгж идэвхэжнэ. Ангиллын хэмжих нэгж нь хэлцлийн хэмжих нэгжээс өөр байгаа тохиолдолд ангиллын тоо хэмжээг тооцон гаргахдаа хэлцлийн хэмжих нэгжийн тоон утгыг ангиллын хэмжих нэгжээр илэрхийлж, хэлцлийн тоо хэмжээгээр үржүүлж тооцно. Жишээ нь: Цагаан будааны хэлцлийн хэмжих нэгж нь тонн бол Уялдуулсан системийн дагуу ангиллын хэмжих нэгж нь кг байдаг. Иймд цагаан будааны хэлцлийн тоо хэмжээ 119 тонн, ангиллын тоо хэмжээ 119,000 кг болно.
Шилжих коэффициент	БТКУС-ийн ангилал хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн суурь нэгж үнийг программаас автоматаар тооцож гаргадаг.
Баглаа боодол	Эхний хэсэгт тухайн барааны баглаа боодлын тоо ширхгийг, дараагийн хэсэгт баглаа боодлын хэмжих нэгжийг сонгож оруулна.

Цэвэр жин	Цэвэр жин (вес нетто, net weight) бараатай хамт хэрэглэгчид очих, жижиглэн худалдаалахаар борлуулагдах баглаа боодлын жинг цэвэр жинд оруулж тооцож кг-аар илэрхийлж бичнэ.
Бохир жин	Хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн зориулалттай баглаа боодлын жинг бохир жинд оруулан тооцож кг-аар илэрхийлнэ. Бохир жин (вес брутто, gross weight) барааны доторх болон гаднах хайрцаг, шуудай, торх, шил гэх мэт тооцсон жинг ойлгоно. Өөрөөр хэлбэл бохир жин гэдэг нь барааны жинд түүний гаднах баглаа боодлыг оруулсан жин юм.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

← Жагсаалт

Мэдүүлгийн дугаар	I-12121675-00012	Горим	400	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	БЯМБАСҮРЭН	Мэдүүлсэн огноо	2021-09-28 12:00	Барааны нэр төрөл	-
Барааны байршил	{302001} АБТЭМА	Мэдүүлгийн төлөв	Хадгалсан		

<p>✓ Үндсэн мэдээлэл Худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл нөхөн бичих</p> <p>✓ АЧАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ Бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих</p> <p>3 БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нөхөн бичих</p> <p>4 БИЧИГ БАРИМТЫН МЭДЭЭЛЭЛ Худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах</p>	<p>Нийт бараа: 2</p> <p>Бичсэнээс хуулах + Бараа нэмэх</p> <table border="1"> <thead> <tr> <th><input type="checkbox"/></th> <th>#</th> <th>Барааны нэр Улс</th> <th>Хэлцлийн тоо хэмжээ</th> <th>Хэлцлийн нэгж үнэ</th> <th>Баглаа боодол</th> <th>Нийт татварын дүн</th> <th>Үйлдэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td><input type="checkbox"/></td> <td>1</td> <td>Төмөр утас, гагнуурын IN</td> <td>150 U</td> <td>81.25 AUD</td> <td></td> <td>54,753,714.48 MNT</td> <td>👁 🗑 ✎ 🔗</td> </tr> <tr> <td><input type="checkbox"/></td> <td>2</td> <td>Химийн индикатор, 4-р зэргийн TR</td> <td>1560 BX</td> <td>3.36 EUR</td> <td>14 CT</td> <td>19,396,943.30 MNT</td> <td>👁 🗑 ✎ 🔗</td> </tr> </tbody> </table> <p>< 1 > 10 / хуудас</p> <p>< Буцах Хянах Үргэлжлүүлэх ></p>	<input type="checkbox"/>	#	Барааны нэр Улс	Хэлцлийн тоо хэмжээ	Хэлцлийн нэгж үнэ	Баглаа боодол	Нийт татварын дүн	Үйлдэл	<input type="checkbox"/>	1	Төмөр утас, гагнуурын IN	150 U	81.25 AUD		54,753,714.48 MNT	👁 🗑 ✎ 🔗	<input type="checkbox"/>	2	Химийн индикатор, 4-р зэргийн TR	1560 BX	3.36 EUR	14 CT	19,396,943.30 MNT	👁 🗑 ✎ 🔗
<input type="checkbox"/>	#	Барааны нэр Улс	Хэлцлийн тоо хэмжээ	Хэлцлийн нэгж үнэ	Баглаа боодол	Нийт татварын дүн	Үйлдэл																		
<input type="checkbox"/>	1	Төмөр утас, гагнуурын IN	150 U	81.25 AUD		54,753,714.48 MNT	👁 🗑 ✎ 🔗																		
<input type="checkbox"/>	2	Химийн индикатор, 4-р зэргийн TR	1560 BX	3.36 EUR	14 CT	19,396,943.30 MNT	👁 🗑 ✎ 🔗																		

Зураг 17. Барааны мэдээлэл алхмын барааны жагсаалт хэсэг

Бичиг баримтын мэдээлэл оруулах алхам

“Бичиг баримтын мэдээлэл” алхам нь худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах хэсэг бөгөөд **“Бичиг баримт нэмэх”** товч дарахад бичиг баримтын мэдээлэл оруулах цонх гарч ирнэ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

Жагсаалт

Мэдүүлгийн дугаар	I-12126502-00001	Горим	400	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	ДОЛГОРЖАВ	Мэдүүлсэн огноо	2021-10-04 12:00	Барааны нэр төрөл	-
Барааны байршил	{301005} ГЕГ БДШГ	Мэдүүлгийн төлөв	• Хадгалсан :		


Үндсэн мэдээлэл
Худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл нөхөн бичих

АЧАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ
Бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих

БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ
Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нөхөн бичих

4 БИЧИГ БАРИМТЫН МЭДЭЭЛЭЛ
Худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах.

Нийт бичиг баримт 0 + Бичиг баримт нэмэх

Бичиг баримтын нэр	Тайлбар	Дугаар	Огноо	Хуудас	Файл	Үйлдэл
 Мэдээлэл бүртгээгүй байна.						

< Буцах 🔍 Хянах ⌵ Илгээх

Зураг 18. Бичиг баримтын мэдээлэл алхмын бүртгэх хэсэг

Бичиг баримтын мэдээлэл оруулах цонх нь дараах байдлаар харагдана. Барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтуудыг PDF форматаар хавсаргаж оруулах бөгөөд нэр, тоо, дугаар, хавсаргах файлуудыг харгалзах хэсэгт бүрэн бичин **“Хадгалах”** товч дарснаар бичиг баримтын мэдээллийг бүртгэнэ.

БИЧИГ БАРИМТ БҮРТГЭХ ✕


* Бичиг баримтын нэр:

* Дугаар:

* Огноо:

* Хуудас:

* Файл:


 gaali-mn-...

Тайлбар:

Болих
📎 Хадгалах

Зураг 19. Бичиг баримтын мэдээлэл бүртгэх цонх

Хүснэгт 4. Бичиг баримтын мэдээлэл хавсаргах хэсгийн талбаруудын талбар

Талбарын нэр	Дэлгэрэнгүй тайлбар
Бичиг баримтын нэр	Хавсаргах бичиг баримтын нэрийг системд тодорхойлсон төрлөөс сонгож оруулна. Системд байхгүй бичиг баримтын төрлийг оруулах бол “Бусад” гэснийг сонгохыг анхаарна уу.
Дугаар	Хавсаргах бичиг баримтын дугаарыг гараас бичиж оруулна.
Огноо	Хавсаргах бичиг баримтын огноог гараас бичиж оруулна.
Хуудас	Хавсаргах бичиг баримтын хуудасны тоог гараас бичиж оруулна.
Файл	“Файл” хэсэгт дарж тухайн бичиг баримтыг PDF форматаар хавсаргаж оруулна.
Тайлбар	Нэмэлт шаардлагатай тайлбар оруулах бол гараас бичиж оруулна. Энэ талбар нь заавал бөглөх албар биш болно.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН МЭДҮҮЛЭГ

← Жагсаалт

Мэдүүлгийн дугаар	I-12121675-00009	Горим	403	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	БЯМБАСҮРЭН	Мэдүүлсэн огноо	2021-09-28 12:00	Барааны нэр төрөл	6
Барааны байршил	[302024] Техник импорт	Мэдүүлгийн төлөв	Хадгалсан		

✓ **Үндсэн мэдээлэл**

Худалдах, худалдсан авахтай холбоотой эзэлхийн мэдээлэл нөхөн бичих

✓ **АЧАА ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ**

Барээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл нөхөн бичих

✓ **БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ**

Барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт мэдээлэл нөхөн бичих

4 **БИЧИГ БАРИМТЫН МЭДЭЭЛЭЛ**

Худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах

Нийт бичиг баримт 10

+ Бичиг баримт нэмэх

Бичиг баримтын нэр	Тайлбар	Дугаар	Огноо	Хуудас	Файл	Үйлдэл
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр		XX-05/23/3198	2013-06-19	1		
Баллаа боодлын жагсаалт		20210831	2021-08-31	1		
Proforma Invoice		10112357-2656&2811-12	2021-08-31	1		
Импортын лиценз		003/21/5881	2021-09-08	1		
Экспорт, импортын гэрээ		C1400204320200109	2021-01-01	1		
Бусад		000012898	2005-11-28	1		
Бусад		02/2322	2021-09-23	1		
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр		125/02	2021-04-01	1		
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар		125/02	2021-04-01	1		

< 1 > 10 / хуудас

< Буцах Хянах Илгээх

Зураг 20. Бичиг баримтын жагсаалт харуулах хэсэг

Мэдүүлгийн мэдээлэл **“Илгээх”** товч дарахад хяналтын цонх харуулах ба **“Хяналт”** цонхны мэдээлэл ямарч зөрүүгүй үед илгээх боломжтой болно. Хяналтын мэдээлэл зөрж байгаа тохиолдолд зөрүүтэй талбаруудыг системээс **“УЛААНААР”** тодруулан харуулах болно.

ХЯНАЛТ X

● Хяналтын мэдээлэл зөрүүтэй байна! X

Мэдүүлгийн дугаар: I-12121675-00012 Өмнөх мэдүүлгийн дугаар: -
 Бүрдүүлэлтийн горим: Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах
 Барааны байршил: [302001] АБТЭМА Валютын ханшны огноо: 2021-09-28
 Тухайн валютын ханш: 441.06 CNY Ам.долларын ханш: 2849.17

Үзүүлэлт	Валютын код	Мэдүүлгийн ерөнхий дүн	Барааны нийлбэр дүн	Зөрүү
Статистик дүн	USD	193,969.361753	167,905.509483	26,063.852271
Ерөнхий дүн	CNY	1,253,007.950000	1,084,640.050000	168,367.900000
Зардал тооцоогүй дүн	CNY	185,797.000000	17,429.100000	168,367.900000
Нийт зардал	CNY	1,067,210.950000	1,067,210.950000	0.000000
Тээврийн зардал	CNY	1,067,210.950000	1,067,210.950000	0.000000
Даатгалын хураамж	CNY	0.000000	0.000000	0.000000
Нэмэгдэх зардал	CNY	0.000000	0.000000	0.000000
Хасагдах зардал	CNY	0.000000	0.000000	0.000000
Цэвэр жин		0.000	1,026.400	-1,026.400
Бохир жин		0.000	1,096.000	-1,096.000

Хаах

Зураг 21. Хяналт цонх - хяналтын мэдээлэл зөрүүтэй үед харагдах хэсэг

Тухайн хяналт зөрүүтэй **“УЛААНААР”** тодруулан талбаруудыг мэдээллийг засаж, үнэн зөв болгосны дараа **“Хяналт”** цонх зөрүүгүй болж **“Илгээх”** товч идэвхижин мэдүүлгийн мэдээллийг гаалийн байгууллага руу илгээх боломжтой болно.

ХЯНАЛТ					
Мэдүүлгийн дугаар: 02-2121675-21-100008		Өмнөх мэдүүлгийн дугаар: -			
Бүрдүүлэлтийн горим: Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах					
Барааны байршил: [302001] АБТЭМА		Валютын ханшны огноо: 2021-09-28			
Тухайн валютын ханш: 2849.17 USD		Ам.долларын ханш: 2849.17			
Үзүүлэлт	Валютын код	Мэдүүлгийн ерөнхий дүн	Барааны нийлбэр дүн	Зөрүү	
Статистик дүн	USD	1,381.000000	1,381.000000	0.000000	
Ерөнхий дүн	USD	1,381.000000	1,381.000000	0.000000	
Зардал тооцоогүй дүн	USD	1,152.000000	1,152.000000	0.000000	
Нийт зардал	USD	229.000000	229.000000	0.000000	
Тээврийн зардал	USD	194.000000	194.000000	0.000000	
Даатгалын хураамж	USD	0.000000	0.000000	0.000000	
Нэмэгдэх зардал	USD	35.000000	35.000000	0.000000	
Хасагдах зардал	USD	0.000000	0.000000	0.000000	
Цэвэр жин		910.000	910.000	0.000	
Бохир жин		920.000	920.000	0.000	

Зураг 22. Хяналт цонх - хяналтын мэдээлэл зөрүүгүй

Гаалийн байгууллага руу илгээсний дараа мэдүүлэг **“Хүлээн авсан”** төлөвт шилжинэ. Мэдүүлгээ илгээсний дараа засварлаж болохгүйг анхаарна уу. Мэдүүлгийн дугаар нь системээс автоматаар үүсэх бөгөөд тухайн мэдүүлгийг илтгэх цор ганц дугаар болно. Мэдүүлгийн дугаараа ашиглан мэдүүлгийн явцын мэдээллээ шалгах, татвар төлөх боломжтой.


Мэдүүлгийн дугаар	02-2121675-21-100001	Горим	400 l	Гаалийн байгууллага	Бүрдүүлэлтийн 1-р алба
Хүлээн авагч	БЯМБАСҮРЭН	Мэдүүлсэн огноо	2021-09-15 12:00	Барааны нэр төрөл	1
Барааны байршил	[302007] Монгол экспресс	Мэдүүлгийн төлөв	Хүлээн авсан		

Зураг 23. Хүлээн авсан мэдүүлгийн төлөв харагдах хэсэг

Гаалийн мэдүүлгийн мэдээлэл, дагалдах бичиг баримтыг бараатай тулган шалгаж, биет үзлэг хийсний дараа гаалийн хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч, ахлах байцаагч нар баталгаажуулж зөвшөөрснөөр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

Мөн “Гаалийн үйлчилгээний цахим систем”-ийн **“Нүүр хуудас”**-ны мэдүүлгийн дугаар оруулах хэсэгт тухайн мэдүүлгийн дугаараа оруулан тухайн мэдүүлгийн явцын мэдээллээ харж, хянах боломжтой юм.

Хэрэглэгчийн цэстэй ажиллах



Зураг 24. Бүртгэлтэй хэрэглэгчийн цэс харуулах хэсэг

Өөрийн бүртгэлээр нэвтэрсний дараагаар өөрт хамаарах үйлчилгээ, мэдүүлгийн мэдээллээ харах, хянахын тулд сайтын **“Нэвтрэх”** хэсэгт нэвтэрсэн хэрэглэгчийн нэрийг харуулна. Тухайн нэр хэсэг дээр дарахад дэд цэсүүд харагдах ба аль нэг дэд цэс дээр дарснаар бүртгэлтэй хэрэглэгчийн ажиллах цэс рүү үсэрнэ. Энэ хэсгээс хэрэглэгч өөрийн бүртгэлээр тус системээс авсан нийт үйлчилгээ, бүрдүүлэлт, мэдүүлэг гэх мэт түүхчилсэн мэдээллээ харах, хянах боломжтой.

Мэдүүлгийн дугаар	Мэдүүлгийн төлөв	Мэдүүлсэн огноо	Горим	Барааны нэр төрлийн тоо	Статистик дүн (\$)	Нийт татвар (₮)	Илгээгч / Хүлээн авагч	Тээврийн хэрэгслийн дугаар	Илгээсэн огноо	Байцаагч
Импорт I-12126502-00001	Төлөв: Хадгалсан Огноо: 2021-10-04	2021/10/04	4001	0	12,000.00	0.00	ee	5736УБО	-	ББГУБ, ХШГУБ
Экспорт I-12121631-00004	Төлөв: Хадгалсан Огноо: 2021-09-29	2021/09/29	9101	1	12,000.00	68,805,523.26	ая	-	-	ББГУБ, ХШГУБ
Экспорт E-12121631-00002	Төлөв: Хадгалсан Огноо: 2021-09-23	2021/09/23	9101	0	370.88	0.00	pp	-	-	ББГУБ, ХШГУБ
Импорт I-12121631-00003	Төлөв: Хадгалсан Огноо: 2021-09-23	2021/09/23	4001	0	3,600.00	0.00	Лхагваа	-	-	ББГУБ, ХШГУБ
Импорт 02-2121631-21-100001	Төлөв: Хүлээн авсан Огноо: 2021-09-14	2021/09/14	4001	1	960.00	423,949.06	mmmm	5736УБО	2021/09/14 15:17	ББГУБ: 0318 ХШГУБ: 0878

Зураг 25. Бүртгэлтэй хэрэглэгчийн цэстэй ажиллах хэсэг